



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

┌ Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор ┐  
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-д доор дурдсан агуулгатай дараах 3.1.23, 3.1.24, 3.1.25 дахь заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.23, 3.1.24, 3.1.25 дахь заалтууд:

“3.1.23. Даатгалын компани нь нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

3.1.24. Тус журмын 3.1.23-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.


3.1.25. Даатгалын компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллавал зохино.”

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 5.8 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/“5.8. Энэ журмын 5.1-5.7 дахь заалт нь Жолоочийн албан журмын даатгалд хамаарахгүй.”

3. Нэмэлт, өөрчлөлтийг журамд оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000151